

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ**

2017 оны 02 дугаар сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

Дугаар: Д-2017-01

*Улсын төсвийн хөрөнгөөр геологийн
судалгааны ажил гүйцэтгэгч хуулийн
этгээдийн үйл ажиллагаа, үр дүнгийн
тайланд өгөх зөвлөмжийн төслийг
хэлэлцсэн тухай*

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийг үндэслэн Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэгч хуулийн этгээдийн үйл ажиллагаанд өгөх зөвлөмжийн төслийг хэлэлцсэн гишүүдийн саналыг үндэслэн дараах ЗӨВЛӨМЖ-ийг гаргаж байна.

1. Тухайн судалгааны ажилтай холбоотой хууль, дүрэм, журам, ажил гүйцэтгэх гэрээ болон геологийн даалгаварт заасан үүргээ биелүүлж ажиллах,
2. Геологийн судалгааны ажлын заавар, түүнд тавигдах шаардлагын дагуу хээрийн болон суурин боловсруултын ажлыг гүйцэтгэхэдээ ажлын чанар, үр дүнг сайжруулах талаар байнга анхаарч, холбогдох мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч ажиллах,
3. Судалгааны ажлын явцад тулгарсан хүндрэлтэй, шийдвэрлэж чадахгүй асуудлыг төрийн захиргааны байгууллагад тухай бүрт нь мэдэгдэж шийдвэрлүүлэх,
4. Хээрийн судалгаа эхлэхийн өмнө бэлтгэл ажлыг сайн хангаж, холбогдох төрийн байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авах, орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллаж, хээрийн судалгааны ажил эхэлсэн талаар тухайн төсөл хэрэгжүүлж байгаа орон нутгийн удирдлагаас төрийн захиргааны байгууллагад хандсан мэдээлэл хүргүүлэх,
5. Төслийн ажлыг гардан гүйцэтгэгч ахлах мэргэжилтэн (зураглалын болон эрлийн ахлах геологич)-ээр тухайн чиглэлд мэргэшсэн, зөвлөх мэргэжилтэнг ажиллуулах, төслийн багийг тогтвортой ажиллах нөхцлөөр хангах,
6. Төслийн инженер, техникийн ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор давтан сургалтад тогтмол хамруулах, орчин үеийн арга, аргачлалыг судалгааны ажилдаа нэвтрүүлэх,
7. Лабораторийн шинжилгээний ажлын хөлсийг үр дүнг авсан тохиолдол бүрт хугацаанд нь төлөх,
8. Тайланд хээрийн судалгааны явцад авагдсан дээж материалд петро-геохимийн нарийвчилсан шинжилгээ хийлгэн үр дүнг боловсруулж хурдас, чулуулгын гарал үүсэл, үүссэн геодинамикийн нөхцлийг тодруулах, тектоникийн болон геологийн хөгжлийн түүхтэй уялдуулан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлах,
9. Ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэгийн төлөвийн үнэлгээ өгөх болон эрлийн талбай ялгасан үндэслэл, шалгуур шинж тэмдэг, хүчин зүйлүүдийг тайланд нарийвчилан тусгах, судалгааны ажлаар тогтоосон илрэлийн гарал үүслийг энэхүү зөвлөмжийн 8-д заасны дагуу тайлбарлах, геохими, геофизикийн ажлын үр дүнг ашиглан баталгаажуулах, дараагийн шатны ажлын талаар зөвлөмжид тусгах,
10. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны төсөл хэрэгжүүлэгч хуулийн этгээдүүд хагас, бүтэн жилээр тайлант хугацааны санхүүжилт, нийт санхүүжилт, суутган

авсан тайлангийн барьцаа, 2%-ийн төвлөрүүлэлт болон гүйцэтгэлийн баталгаа, түүний чөлөөлөлтийн хэмжээг захиалагчтай тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.

ТАНИЛЦСАН:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГА,
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА


Б.БААТАРЦОГТ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

УУХҮЯ-НЫ ГЕОЛОГИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА,
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ ДАРГА


Д.ГАНБАТ

БОЛОВСРУУЛСАН:

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН,
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА


Н.ОЮУНЦЭЦЭГ